**ХЭНТИЙ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр Дугаар А/12 Чингис хот

Өргөдлийн хугацаа сунгаж,
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.1.5, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтууд, Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 5 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Авлигатай тэмцэх газраас Хэнтий аймгийн Засаг даргад шилжүүлсэн иргэн Б.Баярмаагийн өргөдөлд дурьдагдсан асуудлуудыг хянан шалгах, мэдээлэл цуглуулах, зарим нотлох баримтыг бүрдүүлэх шаардлагатай байгаа тул өргөдлийн шийдвэрлэж хариу өгөх хугацааг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Өргөдөлд дурьдагсан асуудлуудыг хянаж шалгах, холбогдох нотлох баримт бүрдүүлж тайлбар дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч | Ж.Гантулга | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| Нарийн бичиг | Б.Мөнхжаргал | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Гишүүд | Б.Онончимэг | Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн |
| | С.Амгаланбаатар | Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хэлтсийн дарга, Улсын хяналтын ахлах байцаагч |
| | Д.Дэлэг | Гадаадын иргэн харьяатын газрын зүүн бүс дэх газрын ахлах мэргэжилтэн |
| | Ц.Түвшинхүү | Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор |

3. Өргөдөлд дурьдагсан асуудлуудыг хянаж шалгах, холбогдох нотлох баримт бүрдүүлж тайлбар дүгнэлт гаргах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд удирдан зохион байгуулж, өргөдөл гаргагчид хариуг хугацаанд нь багтаан хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА Ж.ГАНБААТАР